



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/212

Алтай хот

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хүчингүй болгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.2.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2 дахь хэсгийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшил газраа 2 ба түүнээс дээш жил дараалан ашиглаагүй, газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй, гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй иргэн Б.Цэрэндамбын 8208001493 дугаар нэгж талбарт газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосугай.

2.Аймгийн Засаг даргын 2015 оны А/231 дугаар захирамжийн Б.Цэрэндамбад холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээ нь хүчингүй болсон иргэнд захирамж, мэдэгдлийг 14 хоногийн дотор хүргүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т үүрэг болгосугай.

4.Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсэгт заасны дагуу энэхүү захирамжийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэйг дурдсугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР